



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цэцэн-Уул сумын Сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2022/81/СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улиастай сум

2022 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын

тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Ахлах аудитор : Г.Заяа

Утас:92038288

Цахим хаяг:zayag@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
3. Аудитын тайлан	
3.1 Ерөнхий зүйл	
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Материаллаг байдал.....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	16
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
Анхаарах асуудал байхгүй.....	
4. Аудитын илрүүлэлт	17
4.1 Залруулсан алдаа.....	17
4.2 Төлбөрийн акт тогтоогоогүй.....	17
4.3 Албан шаардлага.....	18
4.4 Зөвлөмж.....	
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12

2022.02.25 № 1302/414

танай _____ -ны № _____ -т

ЦЭЦЭН-УУЛ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ С.ГАНБОЛД-д

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цэцэн-уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Цэцэн-уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Цэцэн-уул сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа 2021 оны 02 дугаар сарын 21-ны өдөр манай байгууллагад ирүүлсэн зөрчил нь (Төсвийн тухай хуулийн 8.9.1 дэх заалттай нийцээгүй) байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

010025462

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 сарын 31

Төгрөг

Дансны код	Үзүүлэлт	ҮЛДЭГДЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	71,226,027.55	56,106,040.33
27	АВЛАГА	1,012,581.67	6,816,878.45
28	Ажиллагсадтай холбогдсон авлага	-	650,000.00
31	НДШ-ийн тооцооны авлага	0.17	1,233,231.55
34	Бусад авлага	1,012,581.50	4,933,646.90
35	Байгууллагаас авах авлага	1,012,581.50	1,555,646.90
36	Хувь хүмүүсээс авах авлага	-	3,378,000.00
60	БАРАА МАТЕРИАЛ	70,213,445.88	49,289,161.88
61	Түүхий эд материал	3,166,000.00	1,989,000.00
62	Тусгай зориулалттай материал	600,000.00	600,000.00
63	Эм боох материал	2,566,000.00	1,389,000.00
66	Хангамжийн материал	67,047,445.88	47,300,161.88
67	Бичиг хэргийн материал	1,216,331.20	2,083,489.20
68	Аж ахуйн материал	4,731,050.00	7,471,950.00
70	Түлш шатах тослох материал	27,470,000.00	2,750,000.00
71	Барилгын засварын материал	690,600.00	1,445,300.00
72	Хүнсний материал	15,955,147.00	16,565,105.00
73	Бусад хангамжийн материал	16,984,317.68	16,984,317.68
86	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,571,452,134.66	2,498,954,835.93
106	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,571,452,134.66	2,498,954,835.93
108	Биет хөрөнгө	2,537,340,134.66	2,464,842,835.93
109	Барилга, байгууламж	2,506,741,266.26	2,506,741,266.26
110	Хуримтлагдсан элэгдэл	(66,157,984.99)	(111,638,344.78)
111	Авто тээврийн хэрэгсэл	18,000,000.00	18,000,000.00
112	Хуримтлагдсан элэгдэл	(3,600,000.00)	(6,300,000.00)

113	Машин, тоног төхөөрөмж	154,072,135.00	156,046,135.00
114	Хуримтлагдсан элэгдэл	(125,203,039.50)	(147,739,920.50)
115	Тавилга, аж ахуйн эд хогшил	61,442,765.30	62,070,765.30
116	Хуримтлагдсан элэгдэл	(26,646,468.04)	(32,403,525.98)
122	Бусад үндсэн хөрөнгө	12,276,714.00	12,276,714.00
123	Хуримтлагдсан элэгдэл	(12,276,714.00)	(12,276,714.00)
125	Номын фонд	18,691,460.63	20,066,460.63
126	Биет бус хөрөнгө	34,112,000.00	34,112,000.00
127	Програм хангамж	2,481,770.00	2,481,770.00
128	Хасагдуулга	(831,770.00)	(831,770.00)
129	Бусад биет бус хөрөнгө	32,462,000.00	32,462,000.00
137	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,642,678,162.21	2,555,060,876.26
214	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	2,642,678,162.21	2,555,060,876.26
215	Засгийн газрын хувь оролцоо	2,642,678,162.21	2,555,060,876.26
216	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	237,762,400.64	237,762,400.64
217	Өмч: -Төрийн өмч	237,762,400.64	237,762,400.64
223	Хуримтлагдсан үр дүн	2,216,611,926.84	2,128,994,640.89
224	Өмнөх үеийн үр дүн	2,216,611,926.84	2,216,611,926.84
225	Тайлант үеийн үр дүн	-	(87,617,285.95)
227	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	188,303,834.73	188,303,834.73
231	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	2,642,678,162.21	2,555,060,876.26

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 сарын 31

Төгрөг

Дансны код	Үзүүлэлт	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	818,798,698.00	794,543,058.18
76	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	18,965,152.00	5,158,900.00
77	Нийтлэг татварын бус орлого	15,378,800.00	5,158,900.00
81	Төсөвт байгууллагын өөрийн орлого	15,378,800.00	5,158,900.00

82	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,293,800.00	4,673,700.00
83	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,542,500.00	485,200.00
86	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,542,500.00	-
99	Тусламжийн орлого	3,586,352.00	-
100	Хандив тусламж /дотоод/	3,586,352.00	-
111	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	55,455,046.00	67,493,858.18
119	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	744,378,500.00	721,890,300.00
122	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,150,846.00	5,438,358.18
127	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,150,846.00	5,438,358.18
129	Орон нутгийн төсвөөс санхүүжих	50,204,200.00	62,055,500.00
130	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	50,204,200.00	62,055,500.00
136	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	2,100,000.00	-
137	Төсвийн захирагчдаас	2,100,000.00	-
147	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	857,930,856.45	882,160,344.13
148	УРСГАЛ ЗАРДАЛ	857,930,856.45	882,160,344.13
149	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	820,103,809.66	863,714,862.14
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	594,134,213.95	590,304,852.03
151	Цалин	594,134,213.95	590,304,852.03
157	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,247,503.62	75,893,342.64
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	50,488,302.54	52,302,214.64
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	5,939,800.77	5,897,781.00
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	4,751,838.62	4,718,225.00
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,187,961.15	1,179,556.00
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	11,879,600.54	11,795,566.00
164	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,542,347.86	85,001,292.14
165	Гэрэл цахилгааны зардал	5,214,307.86	5,236,792.14
166	Түлш, халаалтын зардал	27,073,040.00	79,265,000.00

167	Цэвэр, бохир усны зардал	255,000.00	499,500.00
170	Хангамж, бараа материалын зардал	7,297,584.50	7,526,684.60
171	Бичиг хэргийн материал	1,297,850.00	573,200.00
172	Тээвэр, шатахууны зардал	4,404,834.50	5,195,684.60
173	Шуудан холбоо интернетийн төлбөр	867,400.00	829,800.00
176	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	134,500.00	-
177	Аж ахуйн материал худалдан авах зардал	593,000.00	928,000.00
181	Нормативт зардал	24,277,461.00	26,002,892.00
182	Эм	-	1,677,000.00
183	Хоол	24,277,461.00	24,160,892.00
184	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	165,000.00
185	Эд хогшил, урсгал засварын зардал	195,500.00	411,000.00
189	Урсгал засвар	195,500.00	411,000.00
190	Томилолт, зочны зардал	350,000.00	336,000.00
192	Дотоод томилолтын зардал	350,000.00	336,000.00
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	5,959,200.00	740,000.00
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,959,200.00	-
196	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	-	740,000.00
209	Бараа үйлчилгээний бусад зардал	81,099,998.73	77,498,798.73
211	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	3,725,700.00	1,024,500.00
212	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	77,374,298.73	76,474,298.73
224	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,827,046.79	18,445,481.99
228	Бусад урсгал шилжүүлэг	10,273,046.00	15,263,600.00
232	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,622,200.00	13,410,600.00
235	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,150,846.00	-
236	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	500,000.00	1,853,000.00
237	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	27,554,000.79	3,181,881.99

240	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,554,000.79	3,181,881.99
268	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(39,132,158.45)	(87,617,285.95)
288	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	(39,132,158.45)	(87,617,285.95)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 сарын 31

Төгрөг

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагд - сан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	237,762,400.64	68,890,187.00	(98,165,600.16)	208,486,987.48
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	237,762,400.64	68,890,187.00	(98,165,600.16)	208,486,987.48
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	2,353,909,685.45	2,353,909,685.45
2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	237,762,400.64	188,303,834.73	2,216,611,926.84	2,642,678,162.21
2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	237,762,400.64	188,303,834.73	2,216,611,926.84	2,642,678,162.21
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	237,762,400.64	188,303,834.73	2,216,611,926.84	2,642,678,162.21
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	(87,617,285.95)	(87,617,285.95)
2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	237,762,400.64	188,303,834.73	2,128,994,640.89	2,555,060,876.26

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 сарын 31

Төгрөг

Дансны код	Үзүүлэлт	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	813,669,846.00	794,543,058.18
77	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,836,300.00	5,158,900.00
78	Нийтлэг татварын бус орлого	13,836,300.00	5,158,900.00
82	Төсөвт байгууллагын өөрийн орлого	13,836,300.00	5,158,900.00
83	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,293,800.00	4,673,700.00
84	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,542,500.00	485,200.00
111	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	799,833,546.00	789,384,158.18
119	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	744,378,500.00	721,890,300.00
122	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,150,846.00	5,438,358.18
127	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,150,846.00	5,438,358.18

130	Орон нутгийн төсвөөс санхүүжих	52,304,200.00	62,055,500.00
131	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	50,204,200.00	62,055,500.00
137	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжилт	2,100,000.00	-
148	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	807,734,846.00	790,566,058.18
149	УРСГАЛ ЗАРДАЛ	807,734,846.00	790,566,058.18
150	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	769,907,799.21	772,120,576.19
151	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	592,820,894.65	589,580,927.08
152	Үндсэн цалин	438,705,427.92	382,157,228.73
153	Нэмэгдэл	118,604,969.88	175,231,036.06
155	Үр дүнгийн урамшуулал	35,510,496.85	32,192,662.29
158	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	73,923,386.70	78,500,498.97
159	Тэтгэврийн даатгалын шимтгэл	50,384,930.54	57,779,329.86
160	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	5,453,013.30	5,400,097.89
161	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	3,443,105.40	4,319,998.73
162	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	2,326,522.89	1,079,999.25
163	Эрүүл мэндийн даатгалын хураамж	12,315,814.57	9,921,073.24
165	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	49,928,347.86	61,005,292.14
166	Гэрэл цахилгааны зардал	5,914,307.86	5,704,792.14
167	Түлш, халаалтын зардал	43,759,040.00	54,635,000.00
168	Цэвэр, бохир усны зардал	255,000.00	665,500.00
171	Хангамж, бараа материалын зардал	10,629,420.00	9,684,808.00
172	Бичиг хэрэг	1,079,300.00	1,118,358.00
173	Тээвэр, шатахуун	4,822,720.00	5,648,750.00
174	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	867,400.00	829,800.00
177	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,860,000.00	2,087,900.00
182	Нормативт зардал	32,492,850.00	26,015,850.00
183	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,566,000.00	500,000.00
184	Хоол, хүнс	27,068,750.00	24,770,850.00

185	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,858,100.00	745,000.00
186	Эд хогшил, урсгал засварын зардал	-	999,700.00
190	Урсгал засвар	-	999,700.00
191	Томилолт, зочны зардал	350,000.00	336,000.00
193	Дотоод албан томилолт	350,000.00	336,000.00
195	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,959,200.00	740,000.00
196	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	5,959,200.00	-
197	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	740,000.00
209	Бараа үйлчилгээний бусад зардал	3,803,700.00	5,257,500.00
211	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,803,700.00	5,257,500.00
222	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,827,046.79	18,445,481.99
226	Бусад урсгал шилжүүлэг	10,273,046.00	15,263,600.00
230	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	6,622,200.00	13,410,600.00
233	Хөдөө орон нутагт тогвортой ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,150,846.00	-
234	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	500,000.00	1,853,000.00
235	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	27,554,000.79	3,181,881.99
238	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,554,000.79	3,181,881.99
251	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	5,935,000.00	3,977,000.00
252	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
262	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	5,935,000.00	3,977,000.00
263	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,935,000.00	3,977,000.00
264	Дотоод эх үүсвэрээр	5,935,000.00	3,977,000.00
276	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,935,000.00	3,977,000.00
279	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(5,935,000.00)	(3,977,000.00)
305	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00
306	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	(0.00)

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 сарын 31

Төгрөг

	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ДҮН	Хувь
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	784,151,400.00	781,905,968.19	2,245,431.81	99.7
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	784,151,400.00	781,905,968.19	2,245,431.81	99.7
4	Бараа, үйлчилгээний зардал	770,924,800.00	776,642,368.19	(4,282,431.81)	99.4
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	581,910,400.00	589,580,927.08	7,670,527.08	101.32
6	Үндсэн цалин	421,583,000.00	382,157,228.73	(39,425,771.27)	90.65
7	Нэмэгдэл	128,157,600.00	175,231,036.06	(47,073,436.06)	136.73
9	Урамшуулал	32,169,800.00	32,192,662.29	(22,862.29)	100.07
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,557,900.00	78,500,498.97	57,401.03	99.93
12	Тэтгэврийн даатгал	55,281,500.00	57,779,329.86	(2,497,829.86)	104.52
13	Тэтгэмжийн даатгал	5,819,100.00	5,400,097.89	419,002.11	92.80
14	ҮОМШӨ ний даатгал	4,655,300.00	4,319,998.73	335,301.27	92.80
15	Ажилгүйдлийн даатгал	1,163,800.00	1,079,999.25	83,800.75	92.80
16	Эрүүл мэндийн даатгал	11,638,200.00	9,921,073.24	1,717,126.76	85.25
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	68,255,500.00	61,005,292.14	7,250,207.86	89.38
18	Гэрэл цахилгаан	12,678,300.00	5,704,792.14	6,973,507.86	45.00
19	Түлш, халаалт	54,650,000.00	54,635,000.00	15,000.00	99.97
20	Цэвэр, бохир ус	927,200.00	665,500.00	261,700.00	71.78
22	Хангамж, бараа материалын зардал	9,406,800.00	9,279,900.00	126,900.00	98.7
23	Бичиг хэрэг	966,700.00	966,700.00		100
24	Тээвэр (шатахуун)	5,648,800.00	5,648,750.00	50.00	100.00
25	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	800,000.00	829,800.00	(29,800.00)	103.73
26	Ном, хэвлэл	1,450,000.00	1,375,000.00	75,000.00	94.83
28	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	541,300.00	459,650.00	81,650.00	84.9

30	Нормативт зардал	26,160,900.00	22,890,050.00	3,270,850.00	87.5
31	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	1,000,000.00	500,000.00	500,000.00	50.00
32	Хоол, хүнс	24,174,900.00	21,645,050.00	2,529,850.00	89.5
33	Нормын хувцас зөөлөн эдлэл	986,000.00	745,000.00	241,000.00	75.56
34	Эд хогшил худалдан авах	1,000,000.00	999,700.00	300.00	99.97
38	Урсгал засвар	1,000,000.00	999,700.00	300.00	99.97
39	Томилолт, зочны зардал	1,353,300.00	336,000.00	1,017,300.00	24.83
41	Дотоод албан томилолт	1,353,300.00	336,000.00	1,017,300.00	24.83
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	800,000.00	740,000.00	60,000.00	92.50
45	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	800,000.00	740,000.00	60,000.00	92.50
53	Бараа үйлчилгээний бусад зардал	3,480,000.00	3,310,000.00	170,000.00	95.1
55	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,480,000.00	3,310,000.00	170,000.00	95.1
66	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,226,600.00	15,263,600.00	(2,037,000.00)	115.40
70	Бусад урсгал шилжүүлэг	13,226,600.00	15,263,600.00	(2,037,000.00)	115.40
74	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	11,226,600.00	13,410,600.00	(2,184,000.00)	119.45
78	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	2,000,000.00	1,853,000.00	147,000.00	92.65
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	784,151,400.00	783,945,800.00	205,600.00	100.0
98	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	714,895,900.00	721,890,300.00	(6,994,400.00)	100.98
101	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	714,895,900.00	721,890,300.00	(6,994,400.00)	100.98
103	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	69,255,500.00	62,055,500.00	7,200,000.00	89.60
104	Орон нутгийн төсвөөс	69,255,500.00	62,055,500.00	7,200,000.00	89.60
131	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	48.00	48.00	-	100.00

134	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
135	Гүйцэтгэх ажилтан	29.00	29.00	-	100.00
136	Үйлчлэх ажилтан	14.00	14.00	-	100.00
137	Гэрээт ажилтан	4.00	4.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 сарын 31

Төгрөг

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (I)	9,455,208.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,455,208.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,455,208.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,779,908.00
210401	Бичиг хэрэг	151,658.00
	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	1,628,250.000
2105	Нормативт зардал	3,125,800.00
210502	Хоол, хүнс	3,125,800.00
213209	Бараа үйлчилгээний бусад зардал	4,549,500.000
	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,549,500.000
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР (II)	9,455,208.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,597, 258.18
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,438,358.18
	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	5,158,900.00
131104	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,673,700.00
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	485,200.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Цэцэн-Уул сумын 9 жилийн сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Заяа, хяналтыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын ахлах аудитор Б.Дагвасүрэн, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Цэцэн-Уул сумын 9 жилийн сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдөр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Цэцэн-Уул сумын 9 жилийн сургууль нь боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага юм. 2021 оны хичээлийн жилд эрүүл аюулгүй орчинд багаар ажиллах чадвартай, суралцахуйг дэмжсэн, чанартай боловсролыг эрхэмлэсэн, бүтээлч хамт олон болох зорилгыг дэвшүүлэн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт, дотоод аудитын нэгж хэлтэс байхгүй, үйл ажиллагааны заавар журам гаргаж мөрдөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторроос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цэцэн-Уул сумын 9 жилийн сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 801.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 12.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 9.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	1,012.6	6,816.9	5,804.3
Бараа материал	70,213.4	49,289.2	-20,924.2
Үндсэн хөрөнгө	2,571,452.1	2,498,954.8	-72,497.3
Нийт хөрөнгө	2,642,678.2	2,555,060.9	-87,617.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,642,678.2	2,555,060.9	-87,617.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,642,678.2	2,555,060.9	-87,617.3

Авлага дансны үлдэгдэл 5,804.3 мянган төгрөгөөр өссөн нь Тэмүүлэлтэй багачууд хөтөлбөр бүрэн хэрэгжээгүйгээс 3,378.0 мянган төгрөгийн авлага, төсвийн хэмнэлтийг төвлөрүүлээгүйгээс шалтгаалан 3,438.9 мянган төгрөгийн авлага тус тус үүссэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 20,924.2 мянган төгрөгөөр буурсан нь бараа материалын үлдэгдлээс зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 72,497.3 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардал хасагдсантай холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 87,617.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 714,895.9 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 69,2555.0 мянган төгрөгийн, нийт 784,151.4 мянган төгрөгийн санхүүжилт авахаар тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 721,890.3 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 62,055.5 мянган төгрөгийн, нийт 783,945.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 781,906.0 мянган төгрөгийг зарцуулан, 2,039.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

2021 онд нэмэлт санхүүжилтээр 10,597.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлэн, 9,455.2 мянган төгрөгийг, хангамж бараа материал, нормативт зардал, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд зарцуулан, 1,142.1 мянган төгрөгийг төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн хэмнэлтийг төвлөрүүлээгүйгээс шалтгаалан 3,438.9 мянган төгрөгийн авлага бүртгэсэн, Сумын Засаг дарга сургуулийн захиралд 345.8 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг үр дүнгийн урамшуулал олгосон шалгуур үзүүлэлтээр дүгнэж холбогдох журмыг зөрчсөн, 67,100.0 мянган төгрөгийн худалдан авалтын и-баримтыг бүрдүүлээгүй, санхүүгийн тайлан гаргахдаа 7,200.0 мянган төгрөгийн орлогыг сумын Төрийн сантай тулгаагүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант онд 1,500.0 мянган төгрөгөөр зах зээлийн үнээс өндөр үнэтэй хүнсний материал худалдан авсан, 1,046.5 мянган төгрөгийн хоолны зардлыг зориулалт бусаар зарцуулсан, 3,766.7 мянган төгрөгийн худалдан авалтын и-баримтыг бүрдүүлээгүй, “Си-Ти-Эс”- ХХК-аас нийлүүлэгдсэн 1,650.0 мянган төгрөгийн өртөгтэй санхүүгийн программыг зориулалтын дагуу ашиглаагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хэрэгжилтийг программаар шалгахад тайлант хугацаанд оруулбал зохих 22 мэдээллээс 18 мэдээллийг байршуулан, доорх 4 мэдээллийг байршуулаагүй байна.

- ✓ 2020 оны санхүүгийн тайлан
- ✓ 2020 оны аудитын тайлан, дүгнэлт
- ✓ 2020 оны аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
- ✓ 6,816.9 мянган төгрөгийн авлагын мэдээлэл, үүсгэсэн шийдвэр

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийн хэмнэлтийг төвлөрүүлээгүйгээс шалтгаалан 3,438.9 мянган төгрөгийн авлага бүртгэсэн, Сумын Засаг дарга сургуулийн захиралд 345.8 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг үр дүнгийн урамшуулал олгдог шалгуур үзүүлэлтээр дүгнэж олгосон нь холбогдох журмыг зөрчсөн, 67,100.0 мянган төгрөгийн худалдан авалтын и-баримтыг бүрдүүлээгүй зөрчлүүдийг хэрхэн залруулсныг шалгана.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 85,313.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 70,533.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 7,963.1 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 6,816.9 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

4.1 Залруулсан алдаа

Мөнгөн гүйлгээний тайланд 7,200.0 мянган төгрөгийн орлогын гүйлгээг залруулан, 63,333.3 мянган төгрөгийн худалдан авалтын и баримтыг хэвлэн баримтад хавсаргасан.

4.2 Төлбөрийн акт тогтоогоогүй

4.2.2 Албан шаардлага

Тайлант онд 1,500.0 мянган төгрөгөөр зах зээлийн үнээс өндөр үнэтэй хүнсний материал худалдан авсан, 1,046.5 мянган төгрөгийн хоолны зардлыг зориулалт бусаар зарцуулсан, 3,766.7 мянган төгрөгийн худалдан авалтын и-баримтыг бүрдүүлээгүй, “Си-Ти-Эс”- ХХК-аас нийлүүлэгдсэн 1,650.0 мянган төгрөгийн өртөгтэй санхүүгийн программыг зориулалтын дагуу ашиглаагүй зөрчлүүдийг таслан зогсоож, давтан гаргуулахгүйн тулд албан шаардлага хүргүүлээ.

4.3 Зөвлөмж

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

1. Шилэн дансны хэрэгжилтийг программаар шалгахад тайлант хугацаанд оруулбал зохих 22 мэдээллээс 18 мэдээллийг байршуулан, 6,816.9 мянган төгрөгийн 4 мэдээллийг байршуулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6.1.2; 6.1.4; 6.1.5; 6.4.4; 6.4.5 дахь заалтуудад заасан мэдээллийг шилэн дансны мэдээллийн цахим системд байршуулах гэж заасныг зөрчсөн байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, мэдээллийг хугацаанд нь үнэн зөв байршуулж хэвших.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/мянган төгрөгөөр/							
				Үүнээс				Зөвлөмж			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага	
1.	Цэцэн-Уул сумын сургууль	4	85,313.3	2	70,533.3			1	7,963.1	1	6,816.9